



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/15

Хэрлэн сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жимобайл" ХХК-аас Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн ЦХХХЯ/20240101004 дугаар тендер сонгон шалгаруулалтыг явуулахыг даалгасан аймгийн Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулах талаар нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн (Ц.Бат-Эрдэнэ)-д олгож, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг итгэмжлэгдсэн төлөөлөгчид даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРДОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  А.ЖАРГАЛСАЙХАН

